МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАН

Сэдэв:“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт (2008 оноос хойших хугацаанд) төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, Засгийн газраас хариуцан төлж байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал, хэрэгжилт”

Зохион байгуулсан огноо:
2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр
(09 дүгээр сарын 29-ний өдрийн сонсгол ирц бүрдээгүй)

Улаанбаатар хот
Төрийн ордон

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР.ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

2.1.Оролцогчдын тоо

2.2.Илтгэл, танилцуулга хийсэн байгууллага, албан тушаалтан

ГУРАВ.СОНСГОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн сонсгол

3.2.2026 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр товлосон сонсгол ирц бүрдээгүй

ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ, АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА, ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

4.1.Салбарын бодлого, өнөөгийн нөхцөл байдал

4.2.Төрөөс олгосон дэмжлэгийн хэрэгжилт, үр дүн

4.3.Төрийн дэмжлэгийн шинжээчийн дүгнэлт

4.4.Урамшууллын төрөл, хүртээмж, үр дүн

4.5.Урамшууллын шинжээчийн дүгнэлт

4.6.Гадаадын зээл, тусламж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудит

ТАВ.ОРОЛЦОГЧ, МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО, ИРГЭДИЙН САНАЛ, ТАЙЛБАР, БАЙР СУУРЬ

5.1.Сонсголын үеэр илэрхийлсэн нийтлэг санал, байр суурь

5.2.Бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээлэл

ЗУРГАА.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ

ДОЛОО.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН БАЙР СУУРЬ

НАЙМ.СОНСГОЛ ДАРГАЛАГЧИЙН ДҮГНЭЛТ

ЕС.ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

АРАВ.ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд дотоодын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, малчид, тариаланчдын орлогыг өсгөх, түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулахад төрөөс бодлогоор татаас, дэмжлэг, урамшууллыг олгож ирсэн хэдий ч жил ирэх бүр өсөж, зорилтот үр дүндээ хүрэхгүй байгааг Үндэсний аудитын тайланд тодорхой дурдсан. Иймд төрөөс хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа дэмжлэг, урамшуулал, зээлийн хүүгийн татаасын үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах зэргээр салбарын бодлогыг боловсронгуй болгох, хариуцлагыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгаас 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн УИХ-03/4581 дугаар албан бичгээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад хандаж гаргасан.

Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулахыг дэмжиж Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, О.Амгаланбаатар, А.Ариунзаяа Х.Баасанжаргал, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Б.Баярбаатар, Х.Булгантуяа, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, П.Ганзориг, М.Ганхүлэг, Б.Жаргалан, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, Н.Наранбаатар, Г.Очирбат, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин А.Ундраа, Б.Уянга, Г.Уянгахишиг С.Цэнгүүн, Ө.Шижир, Л.Энхнасан, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нарын 33 гишүүн гарын үсэг зурсан байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын Ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулах бөгөөд энэ дагуу Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн ”Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” 03 дугаар тогтоолоор ”Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт (2008 оноос хойших хугацаанд) төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, засгийн газраас хариуцан төлж байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал, хэрэгжилт” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтож сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайг томилсон.

Мөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор уг сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, А.Ундраа, Б.Уянга нарын 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайг томилсон болно.

Сонсгол зохион байгуулах Ажлын хэсэг 2026 оны 08 дугаар сарын 18,19-ний өдрүүдэд салбарын мэргэжлийн холбоодтой уулзалт зохион байгуулж, 2026 оны 09 дүгээр сарын 02, 16, 23-ны өдрүүдэд хуралдан Ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангаж, сонсголын хөтөлбөрийг хэлэлцэж баталсан.

Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Төрийн ордонд нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз болон Улсын Их Хурлын цахим сувгаар шууд дамжуулан олон нийтэд хүргэсэн бөгөөд сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг хангах зорилгоор дохионы хэлний орчуулгыг

зэрэг хүргэж ажилласан нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдэх эрхийг хангах, парламентын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон юм.

Сонсголын бэлтгэл ажлын хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойш олгосон дэмжлэг, урамшуулал, зээл, зээлийн хүүгийн татаас, гадаадын зээл, тусламж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, баримт бичгийг холбогдох яам, агентлаг, сан, корпораци, аудитын байгууллага болон бусад байгууллагаас гаргуулж, шинжээчийн дүгнэлт боловсруулсан.

Ерөнхий хяналтын сонсголын эхний өдөр буюу 2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр төрөөс олгосон дэмжлэг, урамшуулал, гадаадын зээл, тусламж болон хөрөнгө оруулалт, аудитын үр дүнг хэлэлцсэн бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс олгосон дэмжлэг, урамшууллын үр нөлөө, хүртээмж, эргэн төлөлт, мэдээллийн ил тод байдал, хяналт, хариуцлага, бодлогын тогтвортой байдлын асуудлыг олон талын оролцоотой хэлэлцэж, цаашид төрийн дэмжлэгийн бодлогын үр ашгийг сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах үндэс бүрдсэн гэж үзэж байна.

Хоёр дахь өдөр буюу 09 дүгээр сарын 29-ний өдөр зээл, зээлийн хүүгийн татаас болон “Шинэ хоршоо”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, ноос, ноолуур, “Цагаан алт”, “Атар-4” зэрэг бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг хэлэлцэхээр төлөвлөсөн боловч Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдээгүй тул сонсгол явагдаагүй.

Үүний улмаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгосон зээл, зээлийн хүүгийн татаасын хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд сонсгох боломжгүй болсон юм.

ХОЁР. ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

”Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт (2008 оноос хойших хугацаанд) төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, Засгийн газраас хариуцан төлж байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал, хэрэгжилт” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын зарыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “...сонсгол явуулах сэдэв, огноо, оролцогч, ажиглагчийг бүртгэх зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулна...” гэж заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр www.parliament.mn цахим хуудаст байршуулсан. Оролцогчдыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.11-д заасны дагуу “...14-өөс доошгүй хоногийн хугацаанд бүртгэнэ...” гэж заасны дагуу 09 дүгээр сарын 21-ний өдрийн 17.00 цаг хүртэл бүртгэв.

2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн сонсгол 09:55 цагт ирц бүрдэж албан ёсоор эхэлсэн. Сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл нийт 162 оролцогч бүртгүүлсэн. Үүнээс төрийн байгууллагын төлөөлөл 65 оролцохоос 42, төрийн бус байгууллага болон иргэдийн төлөөлөл 69 иргэн оролцохоос 42 иргэн оролцсон.

Сонсголд Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд болон холбогдох төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнууд оролцсон бөгөөд холбогдох албан тушаалтнууд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойш төрөөс хэрэгжүүлсэн дэмжлэг, урамшуулал, зээлийн хүүгийн татаас болон санхүүжилтийн бодлого, хэрэгжилтийн талаар тайлбар, мэдээлэл танилцуулсан. Үүнд:

- Шүүхийн ерөнхий зөвлөл;
- Монгол Улсын Ерөнхий аудитор болон Үндэсний аудитын газрын төлөөлөл;
- Монголбанк;
- Шадар сайдын ажлын алба;

- Засгийн газрын хэрэг эрхлэх газар;
- Сангийн яам;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар;
- Гаалийн ерөнхий газар;
- Зээлийн батлан даалтын сан болон бусад холбогдох байгууллагын төлөөлөл оролцсон болно.

Мөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны шийдвэрээр томилогдсон шинжээчдийн баг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойш төрөөс хэрэгжүүлсэн дэмжлэг, урамшуулал, зээлийн хүүгийн татаас болон санхүүжилтийн бодлого, хэрэгжилт, түүний үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, хууль эрх зүйн орчин, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зардал, бүтэц, дэмжлэг, урамшуулал, зээл, зээлийн хүүгийн татаасыг салбарт хэрэгжсэн хөтөлбөр тус бүрээр судалж, дүгнэлт боловсруулан 2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгосон төрийн дэмжлэгийн хэрэгжилт, үр дүн”, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгосон төрийн урамшууллын хэрэгжилт, үр дүн” гэсэн 2 сэдвийг сонсголд танилцуулсан.

Шинжээчдийн дүгнэлт нь сонсголын хэлэлцүүлгийн үндсэн мэдээллийн эх сурвалж болж, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хэлэлцүүлгийн гол агуулгыг бүрдүүлсэн.

Сонсголын үеэр давхардсан тоогоор оролцогч 29 иргэн үг, санал хэлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз болон парламентын шууд дамжуулах суваг ажилласан.

2026 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Байнгын хорооны 29 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирсэн бөгөөд гишүүдийн ирц бүрдээгүй тул сонсгол хийгдээгүй.

2.1. Оролцогчдын тоо

Ангилал	09.28-ны өдөр	Тайлбар
Улсын Их Хурлын гишүүд	15 / 29	Ирц 51.7 хувь
Төрийн байгууллагын төлөөлөл	42	Сонсголд биечлэн оролцсон
Иргэн, хуулийн этгээд, ТББ-ын төлөөлөл	42	Сонсголд биечлэн оролцсон
Санал, тайлбар хэлсэн оролцогч	29	Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн холбоод

2.2. Илтгэл, танилцуулга хийсэн байгууллага, албан тушаалтан

Ерөнхий хяналтын сонсголын үеэр холбогдох яам, төрийн байгууллагаас сайд, албан тушаалтнууд болон Байнгын хорооноос томилогдсон шинжээчдийн төлөөлөл мэдээлэл, танилцуулга хийлээ.

Сонсголын үеэр дараах байгууллага, албан тушаалтнууд үндсэн илтгэл, мэдээллийг хийсэн байна.

№	Танилцуулсан асуудал	Илтгэгч / байгууллага
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2008 оноос хойших бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат
2	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгосон дэмжлэг, түүний хэрэгжилт, үр дүн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ
3	ХХААХҮ-ийн салбарт 2008-2025 онд олгосон дэмжлэг, зарцуулсан санхүүжилт, хэрэгжилт, эрсдэлийн талаарх дүгнэлт	Шинжээч
4	Төрөөс олгож байгаа урамшууллын төрөл, хүртээмж, үр дүн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Болорсүх
5	Гадаадын зээл, тусламж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний аудитын үр дүн	Үндэсний аудитын газар
6	Сүү, мах, ноос, ноолуур, хүнсний ногоо, арьс шир, улаанбуудайд олгосон урамшууллын хэрэгжилт, үр дүнгийн дүгнэлт	Шинжээч

Оролцогчдын болон Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулах байдлаар тайлбар, мэдээлэл өгсөн албан тушаалтнууд:

2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат**,** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн**,** тус яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Хөдөө аж ахуйн корпорацын гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирал Б.Амгалан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар асуултад хариулж, холбогдох тайлбар, мэдээлэл өгсөн байна.

Мөн шинжээчид асуулт, тодруулгад хэд хэдэн удаа хариулсан. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн мэдээлэл, дэмжлэг, урамшуулал, зээлийн хүүгийн татаастай холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэрэг, үнийн дүн, сонсголын бэлтгэлд ирүүлээгүй баримт материал зэрэг асуудлаар тайлбар өгсөн байна.

ГУРАВ. СОНСГОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сонсголын үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу төрийн байгууллагын мэдээлэл, шинжээчийн дүгнэлт, оролцогчдын санал, тайлбар, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариулт, үг хэлэх үе шаттайгаар зохион байгуулав.

1. Сонсгол даргалагч сонсголын зорилго, хамрах хүрээ, дэг, оролцогчдын эрх, үүргийг танилцуулсан;

2. Төрийн байгууллага, холбогдох албан тушаалтан болон шинжээчид мэдээлэл, танилцуулга, дүгнэлтээ танилцуулсан;

3. Оролцогч иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл санал, тайлбар, мэдээлэл өгсөн;

4. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, холбогдох байгууллага, албан тушаалтнаас хариулт, тайлбар авсан;

5. Улсын Их Хурлын гишүүд байр сууриа илэрхийлсний дараа бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг танилцуулж, сонсгол даргалагч дүгнэлт хийсэн.

3.1. 2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн сонсгол

Өглөөний хэсэгт хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, төрөөс олгосон дэмжлэгийн хэрэгжилт, шинжээчийн дүгнэлтийг хэлэлцэв. Үдээс хойших хэсэгт урамшууллын төрөл, хүртээмж, үр дүн, Үндэсний аудитын газрын мэдээлэл болон урамшууллын шинжээчийн дүгнэлтийг хэлэлцэж, оролцогчид болон Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал, байр сууриа илэрхийлсэн. Сонсголын хүрээнд дараах гол асуудлууд хөндөгдөв. Үүнд:

- **Төрийн дэмжлэг, урамшууллын үр нөлөө.** 2008–2025 онд салбарт их хэмжээний дэмжлэг, урамшуулал олгосон боловч тэдгээр нь үйлдвэрлэл, бүтээмж, ажил эрхлэлт, дотоодын хангамж, импортын хамааралд бодитоор ямар үр дүн үзүүлснийг нэгдсэн шалгуураар үнэлэх шаардлагатай асуудал хөндөгдөв. Шинжээчид төрийн дэмжлэгийн бодит өгөөж, үр нөлөөг хэмжих тогтолцоо хангалтгүй байгааг онцолсон.
- **Дэмжлэг, зээлийн хүртээмж, зорилтот бүлэгт хүрсэн байдал.** Малчин, тариаланч, өрхийн болон жижиг үйлдвэрлэгч, хоршоо, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг, санхүүжилт тэгш хүртээмжтэй хүрч байгаа эсэх, банкны барьцаа болон бусад шалгуур жижиг үйлдвэрлэгчдэд хүндрэл учруулж байгаа, нэг иргэн, хуулийн этгээд давтан дэмжлэг, зээл авах боломжтой байгаа эсэх асуудлыг хөндөв.
- **Өр, авлага, эргэн төлөлт, төрийн хөрөнгийн хяналт.** Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөө аж ахуйн корпораци, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотой хугацаа хэтэрсэн болон эргэн төлөгдөөгүй авлага, дамжуулан зээл, гэрээний хэрэгжилт, төрийн хөрөнгийн бүртгэл, эргэн төлөлт, хариуцлагын асуудлыг хэлэлцэв. Шинжээчийн дүгнэлтэд эргэн төлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүйгээс найдваргүй болох эрсдэлтэй авлага хуримтлагдаж байгааг тэмдэглэсэн.
- **Мэдээллийн бүрэн байдал, зөрүү, ил тод байдал.** Сонсголд шаардсан баримт, материал бүрэн ирээгүй, зарим хөтөлбөрийн гэрээ, тушаал, дүрэм, журам, үр дүнгийн тайлан дутуу байсан, яам, сан, корпораци, аудит болон шинжээчдийн тоон мэдээлэл хоорондоо зөрсөн асуудлыг хөндөв. Үүнтэй холбоотойгоор архив, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, төсвийн зарцуулалт болон шийдвэрийн ил тод байдлыг сайжруулах шаардлага тавигдсан.
- **Урамшууллын хүртээмж, бодит үр дүн.** Улаанбуудай, хүнсний ногоо, түүхий сүү, ноос, ноолуур, арьс шир, махны урамшууллын олголт, хүртээмж, үр дүнг хэлэлцэж, урамшууллыг зөвхөн олгосон мөнгөн дүнгээр бус үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээмж, чанар, үйлдвэрлэгчийн орлого, дотоодын хангамж, хэрэглэгчийн үнэ зэрэг бодит үзүүлэлттэй уялдуулан үнэлэх шаардлагатайг хөндөв.
- **Салбарын үйлдвэрлэл, дотоодын хангамж, импортын хамаарал.** Төрөөс олон жил дэмжлэг үзүүлсэн атлаа зарим бүтээгдэхүүний импортын хамаарал өндөр хэвээр байгаа, салбарын экспорт, импортын харьцаа алдагдсан, ажиллагсдын тоо болон бүтээмжийн үзүүлэлттэй төрийн дэмжлэгийн үр дүнг харьцуулан үнэлэх асуудлыг УИХ-ын гишүүд хөндсөн. Мөн газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн орц, техник, тэжээл, үр, бордоо, хадгалалт, боловсруулалт, түүхий эдийн чанар, нийлүүлэлтийн сүлжээний асуудал яригдсан.
- **Аудит, хяналт, хариуцлага болон бодлогын тогтвортой байдал.** Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтад аудитын байгууллагаас илрүүлсэн зөрчил, акт, албан

шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, зөрчил давтагдаж буй шалтгаан, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хэлэлцэв. Үүний зэрэгцээ төрийн дэмжлэг тухайн жилийн төсөв, төсөл, арга хэмжээний санхүүжилтээс хэт хамаарч, урт хугацааны бодлого, залгамж чанар сул байгааг шинжээч болон оролцогчид хөндсөн.

3.2. 2026 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр товлосон сонсгол

Хөтөлбөрийн дагуу 09 дүгээр сарын 29-ний өдөр зээл, зээлийн хүүгийн татаас болон томоохон бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэхээр төлөвлөсөн. Тухайлбал “Шинэ хоршоо хөдөлгөөн”, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ”, ноос, ноолуурын үйлдвэрийг дэмжих арга хэмжээ, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” чиглэл, “Атар-4” арга хэмжээ болон тэдгээртэй холбоотой зээл, зээлийн хүүгийн татаасын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсохоор байсан.

Гэвч Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдээгүй тул 09 дүгээр сарын 29-ний өдрийн сонсгол явагдаагүй. Иймд тухайн өдөр хэлэлцэхээр төлөвлөсөн зээл, зээлийн хүүгийн татаасын асуудал сонсголоор хэлэлцэгдээгүй үлдсэн болно.

ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ, АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА, ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

4.1. Салбарын бодлого, өнөөгийн нөхцөл байдал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат салбарын бодлого, өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулахдаа тус салбар нь хүнсний хангамж, аюулгүй байдал, малчин, тариаланчдын орлого, ажлын байр, үндэсний үйлдвэрлэл, экспортын орлого, улмаар улсын эдийн засгийн тогтвортой байдалтай шууд холбоотой стратегийн салбар болохыг онцолсон. Сайдын сонсголд хийсэн танилцуулгаар 2025 оны байдлаар салбарын нийт үйлдвэрлэл 23.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд хөдөө аж ахуйн эдэлбэр газар 108.8 сая га**,** нийт малын тоо 58.1 сая толгой**,** мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй малчин өрхийн тоо 312.3 мянга байна. Мөн газар тариалангийн үйлдвэрлэлд 15.0 мянган өрх, 1,500 орчим аж ахуйн нэгж**,** хүнсний салбарт 2,600 орчим үйлдвэр, цех**,** хөнгөн үйлдвэрийн салбарт 353 үйлдвэр, 1,769 цех үйл ажиллагаа явуулж байгааг мэдээлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны статистик мэдээллийг нэгтгэсэн танилцуулгаар тус салбарт 689.7 мянган хүн ажиллаж, нийт ажиллагсдын 49.5 хувь**,** ДНБ-ний 34.4 хувийг бүрдүүлсэн байна. Салбарын экспорт 846.1 сая ам.доллар, импорт 2,877.1 сая ам.доллар байсан бөгөөд нийт экспортын 5.4 хувь, нийт импортын 25.4 хувийг тус тус эзэлжээ. Ийнхүү импортын хэмжээ экспортоос ойролцоогоор 3.4 дахин их, салбарын гадаад худалдааны зөрүү 2.0 тэрбум ам.доллар орчим байгааг яамны танилцуулгад дурдсан.

Газар тариалангийн салбарын 2025 оны нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 1.93 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 0.79 их наяд төгрөгт хүрсэн нь 2020 онтой харьцуулахад оны үнээр 1.02 их наяд төгрөгөөр, зэрэгцүүлэх үнээр 475 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд тариалангийн зориулалттай нийт талбай 1.17 сая га, тариалсан талбай 557.7 мянган га, уринш 279.9 мянган га, нийт хураан авсан ургац 1,194.1 мянган тонн байжээ. Газар тариалангийн үйлдвэрлэлд 15 мянган өрх, 1.6 мянган аж ахуйн нэгж оролцож байгааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас танилцуулсан.

Хүнсний үйлдвэрлэлийн хувьд яамны танилцуулгаар 2025 онд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2,934.0 тэрбум төгрөг, ундаа үйлдвэрлэл 1,258.8 тэрбум төгрөг, тамхины

үйлдвэрлэл 43.4 тэрбум төгрөг, нийтдээ 4,192.8 тэрбум төгрөг болсон байна. 2024 онтой харьцуулахад сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.9 хувь, малын махны үйлдвэрлэл 8.3 хувь, хиаман төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.5 хувь, цэвэр усны үйлдвэрлэл 4.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны танилцуулгад 2025 оны байдлаар мах, махан бүтээгдэхүүн 93.7 хувь, малын мах 99.2 хувь, сүү 99.9 хувь, сүүн бүтээгдэхүүн 58.9 хувь, гурил 80.9 хувь, гурилан бүтээгдэхүүн 60.4 хувь, өндөг 66.7 хувь, сахар, чихрийн зүйл 67.9 хувь гэж мэдээлсэн. Түүнчлэн хуурай сүүний импорт 2021 онд 5.4 мянган тонн байсан бол 2025 онд 4.5 мянган тонн болж, ойролцоогоор 17 хувиар буурсан талаар сайд сонсголын үеэр танилцуулсан.

Салбарын бодлогын хүрээнд 2008 оноос хойш нийт 30 орчим үндэсний хөдөлгөөн, аян, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлсэн талаар сайд мэдээлсэн. Эдгээр нь газар тариалан, мал аж ахуй, хүнсний болон хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэлийн суурийг өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, дотоодын хангамжийг нэмэгдүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулахад чиглэж ирсэн байна. Сонсголын үеэр эдгээр бодлого, хөтөлбөрийн үр дүнг зөвхөн хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр бус үйлдвэрлэл, бүтээмж, ажил эрхлэлт, дотоодын хангамж, экспорт, импортын хамаарал зэрэг бодит үзүүлэлтээр үнэлэх шаардлагатай гэсэн асуудлыг онцлон хөндсөн.

4.2. Төрөөс олгосон дэмжлэгийн хэрэгжилт, үр дүн

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгосон дэмжлэгийн хэрэгжилт, үр дүнгийн талаар танилцуулахдаа газар тариалангийн үйлдвэрлэл нь улирлын онцлог, цаг агаар, уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн эрсдэл, эргэлтийн хөрөнгийн дутагдал зэрэг хүчин зүйлээс өндөр хамааралтай учир үйлдвэрлэлийн үндсэн орц, техник, технологийн шинэчлэлийг төрөөс дэмжих шаардлагатай гэж тайлбарласан.

Тариалангийн үйлдвэрлэлийн орцын зардлын бүтцэд үр 10–15 хувь, бордоо 15–25 хувь, ургамал хамгааллын бодис 5–10 хувь, шатахуун 15–20 хувь, техник, засвар 15–25 хувь, хөдөлмөр 10–15 хувийг тус тус эзэлдэг талаар танилцуулсан.

Төрөөс газар тариалангийн салбарт үрийн улаанбуудай, шатахуун, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоо, төмс, хүнсний ногооны техник, нийлэг хальсан хүлэмж зэрэг хэлбэрээр эргэн төлөх нөхцөлтэй дэмжлэгийг олгож иржээ.

Үрийн улаанбуудайн дэмжлэгийн хувьд тариалалтын технологийн шаардлагаар үрийг 5 жил тутам шинэчлэх шаардлагатай бөгөөд улсын хэмжээнд улаанбуудайн үрийн жилийн хэрэгцээг 45–50 мянган тонн гэж тооцсон байна. Яамны танилцуулгаар жилд дунджаар 308 тариаланч, аж ахуйн нэгжид 7.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий 9.8 мянган тонн үрийн улаанбуудайг 10–30 хувийн урьдчилгаа төлбөртэй, үлдэгдлийг намрын ургацаас төлөх нөхцөлөөр зээлээр олгож ирсэн. Үүний үр дүнд үрийн шинэчлэл хийж, тариалалтыг технологийн хугацаанд гүйцэтгэх, нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн гэж яамнаас дүгнэсэн.

Шатахууны дэмжлэгийн хувьд жилд дунджаар 1,004 иргэн, аж ахуйн нэгжид 6.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 3.9 мянган тонн шатахууныг 30-50 хувийн урьдчилгаа төлбөртэй, үлдэгдлийг намрын ургацаас нөхөн төлөх нөхцөлтэй зээлээр олгож ирсэн.

Харин 2023–2025 онд шатахууны дэмжлэг олгоогүй байна. Яамны тайлбараар энэхүү дэмжлэг нь тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн.

Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн зээлийн дэмжлэг нь техник, технологийн шинэчлэл хийх, технологийн ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэжээ. Яамны танилцуулгаар үр тарианы техникийн шинэчлэл 82 хувь, зүтгэх хүчний техникийн шинэчлэл 65 хувьд хүрч, хаврын тариалалтыг 14-21 хоног, ургац хураалтыг 26-30 хоногт багтаан дуусгах техникийн боломж бүрдсэн гэж мэдээлсэн.

Төмс, хүнсний ногооны техникийн дэмжлэгийн хүрээнд 2023-2025 онд нийт 330 иргэн, аж ахуйн нэгжид 21.81 тэрбум төгрөгийн техник олгосноос төрөөс үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ 10.05 тэрбум төгрөг байжээ. Үүнээс 2023 онд 95 иргэн, аж ахуйн нэгжид 6.16 тэрбум төгрөгийн техникээс 2.92 тэрбум төгрөгийн, 2024 онд 138 иргэн, аж ахуйн нэгжид 8.62 тэрбум төгрөгийн техникээс 3.89 тэрбум төгрөгийн, 2025 онд 97 иргэн, аж ахуйн нэгжид 7.03 тэрбум төгрөгийн техникээс 3.24 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Төмсний механикжуулалтын түвшин 80 хувь, хүнсний ногооных 55 хувь хүрсэн гэж танилцуулсан.

Бордооны дэмжлэгийн хувьд 2023–2025 онд нийт 794 иргэн, аж ахуйн нэгжид 33.0 мянган тонн бордоонд 11.5 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнээс 2023 онд 182 иргэн, аж ахуйн нэгжид 4.8 мянган тонн бордоонд 3.92 тэрбум, 2024 онд 301 иргэн, аж ахуйн нэгжид 12.5 мянган тонн бордоонд 4.4 тэрбум, 2025 онд 311 иргэн, аж ахуйн нэгжид 15.7 мянган тонн бордоонд 3.2 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. Яамнаас бордооны хэрэглээтэй холбоотой ургацын нэмэгдлийг төмсөнд 19.0 хувь, хүнсний ногоонд 22.0 хувь, улаанбуудайд 13.1 хувь гэж танилцуулсан.

Нийлэг хальсан хүлэмжийн дэмжлэгийн хүрээнд 2007–2024 онд нийт 5,706 хүлэмжийг 15.0524 тэрбум төгрөгийн дүнгээр зээлээр олгосон байна. Хүлэмжийн нийт талбай 2015 оны 68.6 га-аас 2025 онд 159.7 га болж нэмэгдсэн талаар мөн танилцуулсан.

Ийнхүү яамнаас төрийн дэмжлэг нь тариалалтын үндсэн орцын хүртээмжийг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, технологийн хугацааг богиносгох, зарим таримлын ургац, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн гэж танилцуулсан. Харин сонсголын хэлэлцүүлгийн явцад эдгээр үр дүнг зөвхөн олгосон дэмжлэгийн хэмжээ, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор бус, бүтээмж, дотоодын хангамж, орлого, ажил эрхлэлт, импортын хамаарал болон төсвийн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан үнэлэх шаардлагатай гэсэн асуудал хөндөгдсөн.

4.3. Төрийн дэмжлэгийн талаарх шинжээчийн дүгнэлт

Шинжээч төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008–2025 онд олгосон дэмжлэг, зарцуулсан санхүүжилт, хэрэгжилт, эрсдэлийг судалж, нийт дэмжлэгийн хэмжээг 1,102.9 тэрбум төгрөг гэж нэгтгэн тооцсон. Үүнээс газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг дэмжихэд 531.6 тэрбум төгрөг, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд 267.2 тэрбум төгрөг, гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд 304.1 тэрбум төгрөг ногдож байна.

Шинжээч дэмжлэгийн үр нөлөөг салбарын макро болон үйлдвэрлэлийн зарим үзүүлэлттэй харьцуулан авч үзэхдээ 2010 онтой харьцуулахад 2025 онд салбарын ажиллах хүч 31 мянгаар буурсан, салбарын бүтээмж улсын дунджаас 2 дахин бага, 2017 онтой харьцуулахад өрсөлдөх чадвар буурсан гэж дүгнэсэн. Мөн хөдөө аж ахуйн салбарын импортын хамаарал 2010 оноос хойш 5.6 дахин**,** импортын хэмжээ 3.9 дахин нэмэгдсэн гэж танилцуулсан. Импортын өсөлтөд бордоо, азотын эрдэс болон химийн бордоо, тэжээлийн нэмэлт, ууураг, түүхий эд, малын вакцины импорт голлон нөлөөлсөн гэж үзжээ.

Шинжээч дэмжлэгийн хэрэгжилтийг хариуцаж ирсэн Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан, Хөдөө аж ахуйн корпораци болон Жижиг, дунд

үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаа, аудит, хяналт шалгалтын дүнг нэгтгэн авч үзсэн.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2011–2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар 96.8 тэрбум төгрөгийн, Мал хамгаалах сангийн 2011-2018 оны үйл ажиллагаанд 28.3 тэрбум төгрөгийн авлага, өр төлбөр, зээлийн эргэн төлөлттэй холбоотой зөрчил илэрсэн талаар шинжээч танилцуулсан. Хөдөө аж ахуйг дэмжих сан болон Хөдөө аж ахуйн корпорацын 2019–2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өр төлбөрийн баталгаажуулалт, чанаргүй болон найдваргүй болох эрсдэлтэй хуримтлагдсан авлагатай холбоотой 627.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн гэж дурдсан. Мөн газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор 359.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрч байсан талаар мэдээлсэн.

Шинжээчийн танилцуулгад Хөдөө аж ахуйн корпорацаас олгосон дэмжлэгийн эргэн төлөлтийн байдлыг “олгосон 3 төгрөг тутмын 1 төгрөг авлага хэлбэрээр тус корпорацад түгжигдсэн” гэж дүрслэн тайлбарласан. Үүнээс дэмжлэгийн эргэн төлөлт, авлагатай холбоотой асуудал олон жилийн хугацаанд давтагдсан гэж үзжээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотойгоор 2009 оноос хойш олгосон зээлийн мэдээллийг авч үзэхэд шинжээчийн ашигласан материалд 1,286 зээлдэгчид 267.2 тэрбум төгрөгийн зээл олгосон мэдээлэл ирсэн байна. 2025 оны байдлаар Монголбанкны ангиллаар хэвийн бус, хугацаа хэтэрсэн, эргэлзээтэй, муу ангилалд багтсан зээлийг нийлүүлэн тооцоход 51.4 хувьтай болсон гэж шинжээч танилцуулсан.

Шинжээчийн нэгдсэн дүгнэлтээр хөдөө аж ахуйн салбарын төрийн дэмжлэг нь тогтвортой санхүүжилт, үр нөлөө, үр дүнгийн үнэлгээ, эргэн төлөлт, хяналт, хариуцлагын нэгдсэн тогтолцоогүй, олголтод суурилсан шинжтэй байна гэж үзсэн. Тухайлбал:

- байгууллагуудын архивын баримтын бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт нэгдсэн байдлаар хангагдаагүй, цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй;
- дэмжлэгийн бодит өгөөж, үр нөлөөг хэмжиж тооцдоггүйгээс зорилтот үр дүн хангагдсан эсэхийг үнэлэх боломжгүй;
- дэмжлэгийн тогтвортой байдал нь урт хугацааны бодлого, төлөвлөлтөөс илүү тухайн жилийн төсөв, төсөл, арга хэмжээний санхүүжилтээс хамааралтай;
- эргэн төлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүйгээс хугацаа хэтэрсэн, найдваргүй болох эрсдэлтэй авлага хуримтлагдаж, төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна гэж дүгнэсэн

Чиглэл / байгууллага	Шинжээчийн танилцуулгад дурдсан дүн	Гол асуудал
Тариалан эрхлэлтийг дэмжих сан (2011–2018)	96.8 тэрбум төгрөг	Өр, авлага, зээлийн эргэн төлөлт; худалдан авалт, хөрөнгө оруулалт, шийдвэр гаргалт; зориулалт бус зарцуулалт, санхүүгийн зөрчил; хөрөнгийн хамгаалалт, дотоод хяналт
Мал хамгаалах сан (2011–2018)	28.3 тэрбум төгрөг	Өр, авлага, зээлийн эргэн төлөлт; түрээсийн орлого, хөрөнгийн ашиглалтын зөрчил; техник, тоног төхөөрөмжийн борлуулалтын авлага
Хөдөө аж ахуйн корпораци / Хөдөө	627.2 тэрбум төгрөг	Авлага, өглөгийн баталгаажуулалт; чанаргүй, найдваргүй болох эрсдэлтэй авлага; зээл олголт, гэрээний

аж ахуйг дэмжих сан (2019–2025)		хэрэгжилт, эргэн төлөлт; дамжуулан зээлийн эргэн төлөлтийн хүндрэл; хөрөнгө, бараа материалын бүртгэл; худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	2009 оноос хойш 267.2 тэрбум төгрөгийн зээлийн мэдээлэл; 2025 оны байдлаар зээлийн 51.4 хувь нь хэвийн бус, хугацаа хэтэрсэн, эргэлзээтэй, муу ангилалд багтсан гэж шинжээч тооцсон	Зээлийн эргэн төлөлт, авлага, зээлийн чанар; сонгон шалгаруулалт, зориулалт, хяналттай холбоотой асуудал

Шинжээчийн дүгнэлтээр төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон жил их хэмжээний дэмжлэг олгосон боловч дэмжлэгийн бодит үр нөлөө, өгөөжийг хэмжих нэгдсэн шалгуур, мэдээллийн сан, эргэн төлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байна. Мөн дэмжлэгийн хэрэгжилт урт хугацааны бодлого, төлөвлөлтөөс илүү тухайн жилийн төсөв, санхүүжилтээс хамааралтай, өр, авлага болон чанаргүй зээлийн асуудал давтагдсан нь төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна гэж дүгнэсэн.

Мөн архивын баримтын бүрдүүлэлт, хадгалалт, цахим мэдээллийн нэгдсэн сан хангалтгүй, бодит өгөөжийг хэмжих шалгуур сул, хугацаа хэтэрсэн болон найдваргүй болох эрсдэлтэй авлага хуримтлагдсан нь төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байгааг тэмдэглэв.

4.4. Урамшууллын төрөл, хүртээмж, үр дүн

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Болорсүх төрөөс олгож байгаа урамшууллын төрөл, хүртээмж, үр дүнгийн талаар танилцуулсан.

Яамны мэдээллээр 2008–2025 онд нийт 931.7 тэрбум төгрөгийн урамшуулал олгож, давхардсан тоогоор 1.6 сая гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна. Үүнд улаанбуудайн урамшуулалд 302.0 тэрбум, хүнсний ногоонд 39.1 тэрбум, хонь, тэмээний ноосонд 269.9 тэрбум, арьс ширэнд 78.7 тэрбум, ноолуурт 174.9 тэрбум, түүхий сүүнд 47.8 тэрбум, нөөцийн мах бэлтгэлд 63.3 тэрбум төгрөг олгосон талаар танилцуулсан.

Ноолуурын нэг удаагийн болон нөөцийн мах бэлтгэлийн үнийн зөрүүний дэмжлэгийг мөн урамшууллын ангилалд хамруулсан болохыг тайлбарлав.

Улаанбуудайн урамшууллын үр дүнд дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, гурилын дотоодын хангамж тодорхой жилүүдэд 99 хувьд хүрсэн боловч гурилын импортын татварын чөлөөлөлтөөс шалтгаалан дотоодын үйлдвэрлэл, зах зээлд хүндрэл үүссэн гэж мэдээлсэн. Хүнсний ногооны урамшууллын хүрээнд 2019 онд 99.5 мянган тонн байсан ургац 2024 онд 282 мянган тоннд хүрч, тариалсан талбай 65.1 хувь, нэгж талбайн ургац 15 хувиар өссөн гэж танилцуулсан.

Түүхий сүүний урамшууллыг сэрүүний улиралд 1 литр тутамд 1,000 төгрөгөөр олгож байгаа бөгөөд сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэж байгааг дурдсан. Мөн хонь, тэмээний ноосны урамшууллын хүрээнд 213 мянга гаруй тонн ноосонд 269.9 тэрбум төгрөг олгосон бол цар тахлын үед малчдын орлогыг дэмжих зорилгоор 203 мянга гаруй малчин, мал бүхий этгээдэд 174.9 тэрбум төгрөгийн ноолуурын нэг удаагийн урамшуулал олгосон талаар мэдээлсэн.

Ийнхүү яамнаас төрийн урамшууллыг дотоодын үйлдвэрлэл, түүхий эдийн нийлүүлэлт, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, малчин, тариаланчдын орлогыг дэмжих бодлогын хэрэгсэл гэж танилцуулсан.

Урамшууллын төрөл, хэмжээг хүснэгтээр харуулсан байдлаар танилцуулсан. Үүнд:

Урамшууллын төрөл	Хугацаа	Олгосон дүн
Улаанбуудай	2008–2025	302.0 тэрбум ₹
Хүнсний ногоо	2022–2025	39.1 тэрбум ₹
Ноос	2011 оноос	269.9 тэрбум ₹
Арьс шир	2014–2025	78.7 тэрбум ₹
Ноолуур	Цар тахлын үеийн нэг удаагийн арга хэмжээ	174.9 тэрбум ₹
Түүхий сүү	2020–2025	47.8 тэрбум ₹
Нөөцийн мах бэлтгэл	2012–2013	63.3 тэрбум ₹

Яамны төлөөлөгчийн тайлбарласнаар 2008–2010 онд зөвхөн улаанбуудайн урамшуулал олгож, жилд 300–800 орчим иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж байсан бол 2011 оноос ноос, арьс шир зэрэг урамшууллыг нэвтрүүлснээр хамрах хүрээ өргөжиж, зарим жилд 100–291 мянган иргэн, малчин, мал бүхий этгээд хамрагдах болсон байна.

Урамшууллын хэрэгжилтийн үр дүнгийн талаар хүнсний ногооны хураасан ургац 2019 онд 99.5 мянган тонн байсан бол 2024 онд 282 мянган тонн болж нэмэгдсэн, 2019–2025 оны харьцуулалтаар тариалсан талбай 65.1 хувь, нэг га-гаас авах ургац 15 хувиар өссөн гэж танилцуулсан. Түүхий сүүний урамшууллыг сэрүүний улиралд нэг литр тутамд 1,000 төгрөгөөр олгож байгааг мэдээлсэн. Мөн ноосны урамшуулалд 213 мянга орчим тонн ноос хамрагдсан, ноолуурын нэг удаагийн урамшууллыг 203 мянга орчим малчин, мал бүхий этгээдэд олгосон талаар дурдсан.

Яамны танилцуулгаар төрийн урамшуулал нь газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эдийн нийлүүлэлтийг дэмжихийн зэрэгцээ малчин, тариаланчдын мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж ирсэн байна. Харин сонсгол даргалагч урамшуулал нь нийгмийн хамгааллын хэрэгсэл бус, малчин, тариаланч, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн гүйцэтгэл, үр дүнг дэмжих бодлогын хэрэгсэл байх ёстойг онцолсон.

4.5. Урамшууллын шинжээчийн дүгнэлт

Шинжээч 2008–2025 онд төрөөс олгосон урамшууллын мэдээллийг улаанбуудай, ноолуур, арьс шир, түүхий сүү, хүнсний ногоо, хонь, тэмээний ноос, мах гэсэн чиглэлээр нэгтгэн судалсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хийсэн мэдээлэл болон сонсголын бэлтгэлийг хангах хүрээнд тус яамнаас ирүүлсэн материалд шинжээчийн тооцсон дүнгийн хооронд 349 тэрбум төгрөгийн зөрүү илэрсэн. Уг зөрүүний шалтгаан, бүрэлдэхүүнийг анхан шатны баримтаар тулган нягтлах шаардлагатай.

Шинжээчийн дүгнэлтээр урамшууллын төрөл тус бүрийн холбогдох журам, тогтоолд үр дүнг хэмжих тодорхой шалгуур, зорилтот түвшин, хугацаа, хариуцлагын механизм хангалттай тусгагдаагүй, мөн олголтын мэдээлэл, үйлдвэрлэлийн бодит үр дүн, төсвийн зарцуулалтын мэдээлэл хоорондоо уялдаагүйгээс урамшуулал зорилгодоо хүрсэн эсэхэд нэгдсэн үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна. Тухайлбал, улаанбуудайн урамшууллын хувьд ирүүлсэн материалын хүрээнд 2008–2025 онд 279.9 тэрбум төгрөгийг 11,829 иргэн, аж ахуйн нэгжид олгосон байна. Үүнээс нийт урамшууллын 35.8 хувь буюу 100 тэрбум төгрөгийг нийт тариаланчдын 1.2 хувьтай тэнцэх 54 аж ахуйн нэгж, нэг өмчлөгчтэй 13 аж ахуйн нэгж 18 тэрбум төгрөгийн урамшуулал авсан гэж шинжээч мэдээлсэн.

Мөн 30 аж ахуйн нэгж хуурамч баримт бичгээр 562.2 сая төгрөгийн урамшуулал авсан талаарх мэдээлэл танилцуулсан. Ургацын нийт хэмжээ өссөн боловч нэг га-гаас авах ургац буурсан үзүүлэлт байгаа тул үр дүнг зөвхөн нийт үйлдвэрлэлийн хэмжээгээр дүгнэх боломжгүй гэж үзсэн.

Түүхий сүүний урамшууллын хувьд 2020–2025 онд 63.4 сая литр сүүнд 47.9 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон боловч холбогдох журам, тогтоолд үр дүнг хэмжих тодорхой шалгуур үзүүлэлт байхгүй тул үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд дүгнэлт хийх боломжгүй гэж үзсэн.

Хүнсний ногооны урамшууллын хувьд ирүүлсэн материалын хүрээнд 39.3 тэрбум төгрөгийг 4,320 иргэн, аж ахуйн нэгжид олгож, 392.4 мянган тонн хүнсний ногоо хамруулсан байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр нэг га-гаас авах ургац 2021 оны 108 центнерээс 2025 онд 147 центнер болж өссөн боловч 2024 оны урамшууллын хэрэгжилтэд хийсэн Сангийн яамны шалгалтаар 75 сая төгрөгөөс дээш урамшуулал авсан 39 иргэн, аж ахуйн нэгжээс 22-т нь зөрчил илэрч, хураасан ургацын хэмжээнээс давсан шар манжин борлуулсан байдлаар 1.3 тэрбум төгрөгийн урамшуулал илүү авсан гэж шинжээч танилцуулсан.

Арьс шир, хонь, тэмээний ноос, мах, ноолуурын урамшууллын хувьд мөн зарим жилийн материал дутуу, мэдээлэл бүрэн бус, үр дүнг хэмжих шалгуур тодорхойгүй байсан тул урамшуулал үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд бүрэн дүгнэлт хийх боломжгүй гэж шинжээч үзсэн.

Шинжээчийн нэгдсэн дүгнэлтээр төрийн урамшууллын тогтолцоо нь “тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн эсэх”-ээс илүү “урамшуулал олгосон хэмжээ”-д төвлөрсөн, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, чиг үүрэг, хариуцлагын зохицуулалт хангалтгүй, урамшууллын олголт, үйлдвэрлэлийн бодит үр дүн, төсвийн зарцуулалтын мэдээлэл хоорондын уялдаа сул байна гэж дүгнэсэн.

4.6. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудит

Үндэсний аудитын газраас хөдөө аж ахуйн салбарт улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний аудитын үр дүнг танилцуулсан.

Аудитаар зарим төсөл, арга хэмжээг зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хангалтгүй үед хэрэгжүүлсэн, хэрэгжилт удааширсан, зогссон, зориулалт өөрчлөгдсөн, зарим зээлийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан, эргэн төлөлт хийгдээгүй, чанаргүй гүйцэтгэлтэй болон ашиглалтгүй хөрөнгө бий болсон, хэрэгжиж дууссан төслийн үр нөлөөг тайлагнаагүй, мэдээллийн ил тод байдал болон хяналт хангалтгүй зэрэг зөрчил илэрснийг танилцуулсан.

Мөн Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй гадаад зээлийн санхүүжилтийн 16.3 хувийг дэмжлэг, бэлэн мөнгө, урамшууллын хэлбэрээр, 18.0 хувийг зөвлөх үйлчилгээнд зарцуулсан нь төслийн үндсэн зорилгын хамрах хүрээг хумих эрсдэлтэй гэж аудит дүгнэсэн.
Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 14 төсөл, арга хэмжээ гадаад зээл, тусламжийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй, зээл, тусламжаар бий болсон хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад тавих хяналт хангалтгүй, дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн эрсдэлтэй байгааг мөн онцолсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2023–2025 оны аудитаар мөн тоног төхөөрөмж, хөрөнгийг сонгон шалгаруулалтгүйгээр иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн, зарим хөрөнгийг түрээс болон үнэ төлбөргүй олгосон боловч гэрээ, бүртгэл, хяналт хангалтгүй, техникийн шаардлага хангаагүй болон ашиглалтгүй хөрөнгө байгаа зэрэг зөрчил давтагдсан. Аудитын дүгнэлтээр төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр

өгөөжөөр нь эрэмбэлэн төлөвлөх, санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой ашиглах шаардлагатай гэж үзсэн.

Аудитаар нийт 56.8 тэрбум төгрөгийн 58 зөрчил илрүүлж, 52.5 тэрбум төгрөгийн зөрчил арилгуулах 41 албан шаардлага, 4.2 тэрбум төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгсөн гэж танилцуулсан. Мөн 2023-2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар тоног төхөөрөмж, хөрөнгийг сонгон шалгаруулалтгүй, харилцан адилгүй нөхцөлөөр иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн, бүртгэл, ашиглалт, эргэн төлөлтийн нөхцөл тодорхой бус зэрэг зөрчил давтагдсан байна.

ТАВ. ОРОЛЦОГЧ, МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО, ИРГЭДИЙН САНАЛ, ТАЙЛБАР, БАЙР СУУРЬ

5.1. Сонсголын үеэр илэрхийлсэн нийтлэг санал, байр суурь

Сонсголын үеэр малчин, тариаланч, фермер, үйлдвэрлэгч, судлаач, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл төрөөс олгож буй дэмжлэг, урамшуулал, зээлийн бодлогын хэрэгжилт, хүртээмж, үр нөлөөний талаар санал, байр суурыа илэрхийлсэн.

Оролцогчдын саналд дэмжлэг, урамшуулал бодит үйлдвэрлэгч, зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхийг илүү нарийвчлан үнэлэх шаардлагатай гэсэн байр суурь давамгайлав. Ялангуяа малчин, өрхийн тариаланч, жижиг үйлдвэрлэгч, фермер, хоршоод банкны барьцаа, шалгуур болон мэдээллийн хүртээмжээс шалтгаалан зээл, дэмжлэгт хамрагдахад хүндрэлтэй байгааг хөндөж, бүс нутаг, аж ахуйн хэмжээ, үйлдвэрлэлийн онцлогийг харгалзсан хүртээмжийн үнэлгээ хийх санал гаргав. Малчин өрхийн зээлийн хүртээмжид иргэний нийгмийн оролцоотой аудит хийх саналыг мөн дэмжиж байв.

Төрийн дэмжлэгийг нэг удаагийн мөнгөн олголтоор бус үйлдвэрлэлийн бүх шат, нэмүү өртгийн сүлжээтэй уялдуулах шаардлагатайг оролцогчид онцолсон. Тухайлбал, сүүний үйлдвэрлэлд фермерийн түвшний тэжээл, оролтын зардал, логистик, боловсруулалт, борлуулалтыг бүхэлд нь авч үзэх, тэжээлийн ургамал тариалагчдад газар тариалангийн бусад үйлдвэрлэлтэй адил дэмжлэг үзүүлснээр тариалан болон эрчимжсэн мал аж ахуйн салбарыг зэрэг дэмжих боломжтой гэсэн санал гарсан.

Урамшууллын тогтолцоог тоо хэмжээний үзүүлэлтээс чанар, бүтээмж, гарал үүсэл, мөрдөн мөшгөх тогтолцоо, бодит үйлдвэрлэлийн үр дүнтэй уялдуулах шаардлагатай гэж үзсэн. Хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн, гарал үүсэл нь тодорхой, хариуцлагатай үйлдвэрлэгчид дэмжлэг, урамшуулал, зээлд давуу байдлаар хамрагдах нөхцөл бүрдүүлэх санал мөн тавигдсан.

Оролцогчид бүс нутгийн ялгаатай нөхцөлийг дэмжлэгийн бодлогод тусгах шаардлагатайг хөндсөн. Говийн бүсийн малчдын хувьд уур амьсгал, бэлчээр, ус, уул уурхайн нөлөөлөлтэй холбоотой эрсдэл, баруун болон зүүн бүсийн тариаланчдын хувьд мэдээлэл, санхүүжилт, зах зээлийн хүртээмжийн ялгааг харгалзан дэмжлэгийг бүсчилсэн байдлаар хэрэгжүүлэх санал гаргав.

Мөн дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд үр, бордоо, тэжээл, техник, хадгалалт, боловсруулалтын дэд бүтэц, борлуулалтын тогтолцоог сайжруулах, дотоодын үр, төмс, хүнсний ногоо болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор хамгаалах, импортын бодлогыг дотоодын үйлдвэрлэлтэй уялдуулах шаардлагатай гэсэн байр суурь илэрхийлэгдсэн.

Түүнчлэн дэмжлэг, урамшууллын талаар мэдээллийг ил тод, хүртээмжтэй болгох, хэн, хэдий хэмжээний дэмжлэг авсан, ямар үр дүнд хүрсэн талаарх мэдээллийг нэгтгэх**,** давтан болон давхар дэмжлэг авсан эсэхийг хянах, төрийн бодлого, хөтөлбөрийн үр дүнг тогтмол үнэлдэг байх шаардлагатайг оролцогчид онцлов.

Нийтлэг байдлаар оролцогчид төрийн дэмжлэг, урамшууллыг бүрэн зогсоох бус зорилтот бүлэгт хүрсэн байдал, үйлдвэрлэлийн бодит үр дүн, чанар, бүтээмж, хүртээмж, хяналт, хариуцлагатай уялдуулан илүү оновчтой болгох шаардлагатай гэсэн байр суурь илэрхийлсэн.

5.2. Бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээлэл

Сонсголд урьдчилан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг сонсголын төгсгөлд танилцуулсан. Үүнд Монголын Тариаланчдын Үндэсний холбоо болон Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооноос ирүүлсэн санал, байр суурийг онцлон дурдсан.

Монголын Тариаланчдын Үндэсний холбоо Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолын хэрэгжилтийг нягтлан шалгаж, тогтоолд тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Тухайлбал, эргэлтийн талбай нэмэгдүүлэх зорилгоор техникийн эргэлтийн 100 метр хүртэлх талбайг ашиглах, чанаргүй болон хөөн хэлэлцэх хугацаа дууссан зээлийг хуульд нийцүүлэн үе шаттай шийдвэрлэх, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үлдэгдэл бараа материал, техник, технологийг 50 хүртэл хувийн хөнгөлөлттэй нийлүүлэх зэрэг арга хэмжээ бодит хэрэгжилтгүй байгааг дурдсан. Иймд дээрх тогтоолын хэрэгжилтийн өнөөгийн байдлыг холбогдох байгууллагаар шалгуулж, гамшиг, давагдашгүй хүчин зүйлээс үүссэн хохирлыг бууруулах, нөхөн сэргээх чиглэлээр гарсан төрийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүсэлт гаргасан.

Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо ноосны урамшууллын бодлого нь үндэсний үйлдвэрүүдийн түүхий эдийн хангамжийг тогтворжуулах, малчдын орлогыг дэмжих, боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж дүгнэсэн. Холбооны мэдээллээр ноос угаах хүчин чадал 25 мянган тонноос 82.2 мянган тонн**,** самнах хүчин чадал 552 тонноос 5,120 тонн болж өссөн байна. Гэвч орон нутагт байгуулсан угаах үйлдвэрүүдийн 60 орчим хувь түүхий эдгүйгээс сул зогсож, үлдсэн үйлдвэрүүд хүчин чадлынхаа 20 хүрэхгүй хувиар ажиллаж байгааг дурдсан.

Тус холбооноос үндэсний үйлдвэрт ноос тушаасан малчинд олгодог мөнгөн урамшууллыг тогтвортой үргэлжлүүлэх, хонины ноосны урамшууллыг килограмм тутамд 2,000 төгрөгөөс дээш**,** тэмээний ноосныхыг 5,000 төгрөгөөс дээш болгох, угаасан ноосны экспортын татварын зохицуулалтыг боловсронгуй болгох, боловсруулаагүй ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврийг нийслэл рүү тээвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, ноос угаах үйлдвэрийн гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой болгох санал гаргасан.

Бичгээр ирүүлсэн саналуудын нийтлэг агуулга нь төрийн дэмжлэг, урамшууллын бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх, өмнө гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, түүхий эдийн бэлтгэл, боловсруулалтын тогтолцоог сайжруулах, малчин, тариаланч, үйлдвэрлэгчдийн бодит хэрэгцээнд нийцсэн дэмжлэгийн механизмыг бий болгоход чиглэж байв.

ЗУРГАА. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ

Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариултын үеэр дараах асуудлууд голлон хөндөгдөв:

Асуудлын бүлэг	Асуулт, хариултын гол агуулга
Мэдээллийн бүрэн байдал, архив	Сонсголд шаардсан баримт, материалын ихээхэн хэсэг ирээгүй, яам, сан, корпораци, шинжээчдийн тоон мэдээлэл хоорондоо зөрүүтэй байгааг гишүүд хөндөв. Олон жилийн бодлого, дэмжлэгийн мэдээлэл байгууллага, албан тушаалтны архив, хадгалалтаас хамаарахгүй

	байх, цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагыг онцолсон.
Зээлийн мэдээллийн сан, давхар санхүүжилт	Төрөөс олгосон хөнгөлөлттэй зээл, сан, корпорацийн зээлийн мэдээлэл Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэгддэг эсэх, нэг иргэн, аж ахуйн нэгж олон эх үүсвэрээс давтан зээл, дэмжлэг авсан эсэхийг тодруулсан. Монголбанк мэдээлэл нийлүүлэх үүрэг бүхий байгууллагуудын зээлийн мэдээлэл санд бүртгэгддэг талаар тайлбар өгсөн.
Өр, авлага, зээлийн эргэн төлөлт	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 96.8 тэрбум, Мал хамгаалах сангийн 28.3 тэрбум, Хөдөө аж ахуйн корпорацтай холбоотой 627.2 тэрбум, дамжуулан зээлийн эргэн төлөлтийн 359.7 тэрбум төгрөгийн асуудлыг хөндөж, өр, авлага яагаад олон жил хуримтлагдсан, хэн авсан, хэрхэн барагдуулж байгаа, хариуцлага тооцсон эсэхийг асуусан.
Дэмжлэгийн үр дүн, эдийн засгийн өгөөж	2008–2025 онд салбарт их хэмжээний дэмжлэг, урамшуулал, зээл олгосон атлаа ажиллах хүч буурсан, бүтээмж сул, импортын хамаарал өссөн үзүүлэлттэй байгааг дурдан, төрөөс зарцуулсан хөрөнгийн бодит өгөөжийг ямар шалгуураар хэмжиж байгааг тодруулсан.
Урамшууллын зорилго, үр нөлөө	Улаанбуудай, хүнсний ногоо, сүү, ноос, ноолуур, арьс шир, махны урамшуулал анх ямар асуудлыг шийдвэрлэх зорилготой байсан, зорилгодоо хүрсэн эсэх, үйлдвэрлэл, бүтээмж, дотоодын хангамж болон хэрэглэгчийн үнэд ямар бодит нөлөө үзүүлснийг асуусан.
Урамшууллын төвлөрөл, зөрчил	Улаанбуудайн урамшууллын тодорхой хэсэг цөөн аж ахуйн нэгжид төвлөрсөн, нэг өмчлөгчтэй 13 аж ахуйн нэгж 18 тэрбум төгрөгийн урамшуулал авсан, 30 аж ахуйн нэгж хуурамч баримтаар 562.2 сая төгрөгийн урамшуулал авсан талаарх мэдээллийн эх сурвалж, уг зөрчлийн шийдвэрлэлтийг тодруулсан.
Хүртээмж, зорилтот бүлэг	Дэмжлэг, зээл, урамшуулал малчин, тариаланч, жижиг үйлдвэрлэгч, хоршоо, өрхийн аж ахуйд бодитоор хүрч байгаа эсэх, нэг иргэн, хуулийн этгээдэд давтан төвлөрч байгаа эсэхийг хөндөж, хүртээмжид иргэний нийгмийн оролцоотой аудит хийх санал гаргасан.
Аудит, хяналт, хариуцлага	Аудитаар илэрсэн зөрчил давтагдаж байгаа шалтгаан, өмнөх шийдвэр гаргагч болон холбогдох албан тушаалтны хариуцлага, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тодруулсан. Мөн сонсголд шаардсан материалыг дутуу ирүүлсэн нөхцөлд хариуцлагын асуудлыг авч үзэх шаардлагатайг хөндсөн.

Хэлэлцүүлгийн үеэр Монголбанк Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй зээл нь арилжааны банкны өөрийн эх үүсвэрээр олгогддог бөгөөд зээлийн мэдээллийн санд нийлүүлэгддэг, зээлийн эргэн төлөлт 90 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн тохиолдолд хүүгийн дэмжлэгийг цуцлах зохицуулалттай талаар тайлбарласан. Мөн төрийн зарим сан, корпораци зээлийн мэдээллээ хуулийн дагуу санд нийлүүлэх үүрэгтэйг мэдээлсэн.

ДОЛОО. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН БАЙР СУУРЬ

Улсын Их Хурлын гишүүд сонсголын үеэр дараах нийтлэг байр суурийг илэрхийлэв:

- **Төрийн дэмжлэг, урамшууллын үр дүнг бодитой хэмжих шаардлагатай.** Дэмжлэг, урамшуулал олгосон мөнгөн дүн, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор үр дүнг хэмжих бус үйлдвэрлэл, бүтээмж, дотоодын хангамж, импортын хамаарал, бүтээгдэхүүний үнэ зэрэг бодит үзүүлэлттэй уялдуулан үнэлж, төсвөөс зарцуулсан хөрөнгийн эдийн засгийн өгөөжийг тодорхой болгох шаардлагатай гэж үзэв.

- **Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих парламентын хяналтыг үр дүнд суурилуулах шаардлагатай.** Төрөөс хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр, дэмжлэгийн арга хэмжээ зорилтот эзэндээ хүрсэн эсэх, ямар үр дүн гарсныг тогтмол хянан үнэлж, цаашдын төсөв, бодлогын шийдвэрт ашиглах шаардлагатайг онцлов.
- **Мэдээллийн бүрэн байдал, үнэн зөв байдлыг хангах шаардлагатай.** Яам, сан, корпораци, аудит, статистик болон шинжээчдийн тоон мэдээлэл хоорондоо зөрүүтэй, сонсголд шаардсан баримт материал дутуу ирсэн нөхцөлд бодитой дүгнэлт хийх боломж хязгаарлагдаж байгааг тэмдэглэж, мэдээллийг нэгтгэн нягталж, ил тод болгох шаардлагатай гэж үзэв.
- **Өр, авлага, эргэн төлөлт болон төрийн хөрөнгийн хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай.** Төрөөс дэмжлэг, зээл авсан иргэн, аж ахуйн нэгж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, эргэн төлөлтөө хугацаанд нь хийх, нэг этгээдэд дэмжлэг давтан төвлөрөхөөс сэргийлэх, хугацаа хэтэрсэн болон чанаргүй авлагыг барагдуулах хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатайг хөндөв.
- **Дэмжлэг, зээлийн хүртээмжийг зорилтот бүлгээр үнэлэх шаардлагатай.** Малчин, тариаланч, жижиг үйлдвэрлэгч, хоршоо зэрэг бодит үйлдвэрлэгчид төрийн дэмжлэг, зээлд тэгш хамрагдаж байгаа эсэхийг тогтоож, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор хүртээмжийн үнэлгээ, хөндлөнгийн аудит хийх нь зүйтэй гэж үзэв.
- **Өмнөх хугацаанд үүссэн зөрчил, дутагдлыг баримтаар тогтоож, шийдвэрлэх шаардлагатай.** Өмнөх сан, байгууллагаас шилжин ирсэн өр, авлага, аудитын зөрчил, дутуу баримт материалыг өнөөгийн удирдлагын асуудалтай хольж ойлгохгүйгээр үүссэн шалтгаан, хугацаа, хариуцсан этгээдийг бодит баримтаар тогтоож, ил тод болгож, цаашид ижил зөрчил давтагдахгүй байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэв.

НАЙМ. СОНСГОЛ ДАРГАЛАГЧИЙН ДҮГНЭЛТ

Сонсгол даргалагч хэлэлцүүлгийг дүгнэхдээ төрөөс олгож буй дэмжлэг, урамшуулал нь зөвхөн олголтын хэмжээгээр бус үйлдвэрлэлийн бодит өсөлт, бүтээмж, дотоодын хангамж, импортын хамаарал, үйлдвэрлэгчийн орлого зэрэг хэмжигдэхүйц үр дүнгээр үнэлэгдэх ёстойг онцлов. Мөн урамшуулал нь нийгмийн хамгааллын хэрэгсэл бус, эрс тэс уур амьсгалын нөхцөлд үйлдвэрлэл эрхэлж буй малчин, тариаланч, аж ахуйн нэгжийн гүйцэтгэл, үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хэрэгсэл байх ёстой гэж тэмдэглэсэн.

Сонсголын явцад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, шинжээч болон бусад эх сурвалжийн мэдээлэл хооронд тоон зөрүү гарсан, ялангуяа урамшууллын мэдээлэлд 349 тэрбум төгрөгийн зөрүү байгааг онцолж, уг зөрүүг тодорхойгүй үлдээхгүйгээр анхан шатны баримт, тушаал, хавсралт, судалгааны мэдээллээр тулган нягталж, нэгдсэн тоон мэдээлэлтэй болох шаардлагатай гэж үзэв.

Цаашид төрийн дэмжлэг, урамшууллын бодлого, хөтөлбөр бүрд зорилго, хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, хариуцлагыг урьдчилан тодорхой болгож, олголтын мэдээллийг үйлдвэрлэлийн бодит үр дүн болон төсвийн зарцуулалттай уялдуулан үнэлдэг тогтолцоонд шилжих шаардлагатайг тэмдэглэсэн. Мөн мэдээллийг нэг мөр, ил тод болгох, бодлогын үр дүн, бүтээмжийг тогтмол хэмждэг байх нь цаашдын шийдвэрийн үндэс болох ёстой гэж дүгнэв.

ЕС. ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Сонсголын явцад төрийн байгууллагын танилцуулга, шинжээчийн дүгнэлт, аудитын мэдээлэл, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, байр суурь, иргэд, мэргэжлийн холбоодын саналд үндэслэн дараах асуудлыг нэгдсэн байдлаар дүгнэв.

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2008 оноос хойш төрөөс олон төрлийн дэмжлэг, урамшуулал, зээл, хөрөнгө оруулалт хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн суурь, техник, технологи, түүхий эдийн хангамж, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тодорхой үр дүн гарсан боловч зарцуулсан хөрөнгийн бодит үр өгөөжийг үйлдвэрлэл, бүтээмж, дотоодын хангамж, импортын хамаарал, үйлдвэрлэгчийн орлого зэрэг нэгдсэн шалгуураар үнэлэх тогтолцоо хангалтгүй байна.
- Төрийн дэмжлэг, урамшууллын бодлого нь зарим тохиолдолд урт хугацааны бодлого, төлөвлөлтөөс илүү тухайн жилийн төсөв, төсөл, арга хэмжээний санхүүжилтээс хамааралтай хэрэгжиж, зорилго, хүрэх үр дүн, хэмжих шалгуур, хугацаа, хариуцлагын зохицуулалт тодорхой бус байгаагаас үр нөлөөг бодитой үнэлэх боломж хязгаарлагдаж байна.
- Яам, сан, корпораци, аудит, статистик болон шинжээчдийн мэдээлэл хоорондоо зөрүүтэй, сонсголд шаардсан баримт материал бүрэн ирээгүй, архив, бүртгэл, цахим мэдээллийн нэгдсэн сан хангалтгүй байгаагаас олон жилийн дэмжлэг, урамшууллын нийт хэмжээ, хүртээмж, үр дүнг нэг мөр тогтооход хүндрэл үүссэн. Иймд анхан шатны баримтад тулгуурлан мэдээллийг тулган баталгаажуулж, нэгдсэн цахим мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагатай байна.
- Төрийн сан, корпорациар дамжуулан олгосон зээл, дэмжлэгтэй холбоотой өр, авлага, хугацаа хэтэрсэн болон эргэн төлөгдөөгүй зээлийн хэмжээ өндөр**,** зарим асуудал олон жил үргэлжилсэн нь эргэн төлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна.
- Урамшууллын бодлогын хувьд олгосон дүн, хамрагдсан тоонд төвлөрөхөөс илүү чанар, бүтээмж, гарал үүсэл, бодит үйлдвэрлэл, дотоодын хангамж, нэмүү өртөг, хэрэглэгчид хүрэх үр нөлөөтэй уялдуулах шаардлагатай байна.
- Дэмжлэг, зээл, урамшууллын хүртээмж малчин, тариаланч, жижиг үйлдвэрлэгч, фермер, хоршоо, бүс нутгийн хувьд харилцан адилгүй байгааг оролцогчид хөндсөн тул зорилтот бүлэгт бодитоор хүрсэн эсэхийг тусгайлан үнэлж, давхар болон давтан дэмжлэгийн эрсдэлийг хянах шаардлагатай байна.
- Үндэсний аудитын байгууллагын дүгнэлтээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ашиглалт, бүртгэл, эргэн төлөлт, хяналт хангалтгүй, ижил төрлийн зөрчил давтагдсан тул аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаатай хянаж, хэрэгжээгүй тохиолдолд хариуцлагын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Иймд цаашид төрөөс олгох дэмжлэг, урамшуулал, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтыг зорилго, хэмжих үзүүлэлт, хүрэх үр дүн, хугацаа, хяналт, эргэн төлөлт, хариуцлагын нэгдсэн тогтолцоотой болгож, мэдээллийн ил тод байдал, хүртээмж, бодит үр нөлөөнд суурилсан бодлогын зохицуулалтад шилжүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.

АРАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Ерөнхий хяналтын сонсголын хэлэлцүүлэг, төрийн байгууллага, шинжээч, аудитын дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүд болон оролцогчдын санал, байр суурийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

1. **Дэмжлэг, урамшууллын мэдээллийн зөрүүг эцэслэн тогтоох.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хөдөө аж ахуйн корпораци, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Сангийн яам, Үндэсний аудитын газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран 2008–2025 онд олгосон дэмжлэг, урамшууллын мэдээллийг сайдын тушаал, гэрээ, төлбөрийн баримт, санхүүгийн тайлан, аудитын мэдээлэлтэй тулган нягталж, төрөл, он, эх үүсвэр, хүлээн авагч, олгосон дүнгээр нэгтгэсэн баталгаажсан мэдээлэл гаргах.

Урамшууллын мэдээлэлд илэрсэн 349 тэрбум төгрөгийн зөрүүний шалтгаан, бүрэлдэхүүнийг тусгайлан тайлбарлаж**,** Байнгын хороонд ирүүлэх.

2. **Салбарын төрийн дэмжлэгийн нэгдсэн цахим бүртгэл бий болгох.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь 2008 оноос хойш олгосон дэмжлэг, урамшуулал, хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн татаас, өр, авлага, эргэн төлөлтийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдийн регистр, санхүүжилтийн эх үүсвэр, хөтөлбөр, он, хэмжээ, үр дүнгээр бүртгэдэг нэгдсэн цахим сангийн бүтэц, мэдээллийн стандартыг боловсруулж, Монголбанк, Сангийн яам, татвар, аудит болон холбогдох байгууллагын мэдээллийн сантай уялдуулах. Ингэснээр нэг этгээд олон эх үүсвэрээс давхар, давтан дэмжлэг авсан эсэхийг шалгах боломжтой болгох.
3. **Дэмжлэг, урамшуулал бүрд үр дүнгийн шалгуур тогтоох.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь улаанбуудай, хүнсний ногоо, сүү, ноос, ноолуур, арьс шир, мах болон бусад дэмжлэгийн төрөл тус бүрээр суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хэмжих үзүүлэлт, мэдээллийн эх үүсвэр, үнэлгээ хийх давтамжийг баталгаажуулах. Үр дүнг зөвхөн олгосон мөнгөн дүнгээр бус нэгж талбайн ургац, бүтээмж, боловсруулалтын түвшин, дотоодын хангамж, импортын хамаарал, бүтээгдэхүүний чанар, нэмүү өртөг, үйлдвэрлэгчийн орлого зэрэг үзүүлэлтээр үнэлдэг болгох.
4. **Өр, авлага, эргэн төлөлтийн тусгай төлөвлөгөө гаргах.** Хөдөө аж ахуйн корпораци, Жижиг, дунд үйлдвэрийн газар болон холбогдох сан, байгууллагууд хугацаа хэтэрсэн, эргэлзээтэй, найдваргүй өр, авлагыг зээлдэгч, гэрээ, үүссэн он, үлдэгдэл, шалтгаан, хэрэгжүүлсэн арга хэмжээний хамт нэг бүрчлэн ангилж**,** барагдуулах хугацаатай төлөвлөгөө батлах. Шүүх, шийдвэр гүйцэтгэл, эвлэрүүлэн төлүүлэх болон боломжгүй болсон авлагыг тусад нь ангилж, хэрэгжилтийг хагас жил тутам Байнгын хороонд мэдээлэх.
5. **Дэмжлэгийн хүртээмж, төвлөрөлд тусгай үнэлгээ хийх.** Дэмжлэг, урамшуулал, зээл нь малчин, тариаланч, фермер, хоршоо, жижиг үйлдвэрлэгч, бүс нутгийн хувьд хэр хүртээмжтэй байсныг хүлээн авагчийн тоо, хэмжээ, газар зүйн байршил, аж ахуйн хэмжээ, давтан хамрагдсан байдал зэрэг үзүүлэлтээр үнэлэх. Нэг этгээд болон харилцан хамаарал бүхий этгээдэд дэмжлэг хэт төвлөрсөн эсэхийг тогтоож, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн оролцоотой хөндлөнгийн үнэлгээ хийх.
6. **Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянах.** Үндэсний аудитын газраас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмж бүрийн хэрэгжилтийн төлөв, хариуцах байгууллага, албан тушаалтан, биелүүлэх хугацаа, үлдэгдэл зөрчлийг нэгтгэн гаргаж, хэрэгжээгүй болон давтан гарсан зөрчилд холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
7. **Архив, анхан шатны баримтын бүрдлийг шалгаж, нөхөн бүрдүүлэх.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагууд дэмжлэг, урамшуулал, зээлтэй холбоотой тушаал, гэрээ, хавсралт, төлбөрийн баримт, үр дүнгийн тайлан, эргэн төлөлтийн мэдээлэл бүрэн байгаа эсэхэд дотоод шалгалт хийж, дутуу баримтыг нөхөн бүрдүүлэх. Баримт байхгүй, устсан, шилжээгүй тохиолдолд шалтгаан, хариуцсан албан тушаалтныг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.
8. **Дэмжлэгийн бодлогыг урт хугацааны салбарын зорилттой уялдуулах.** Жил бүрийн төсөвт дэмжлэг тусгахдаа тухайн жилийн санхүүжилтээс хамаарсан нэг удаагийн арга хэмжээ бус, 3–5 жилийн зорилтот үзүүлэлт, үйлдвэрлэлийн бодит хэрэгцээ, бүс нутгийн онцлог, зах зээлийн төлөв, импорт орлох болон экспортын зорилттой уялдуулан төлөвлөх. Үр дүнгүй, давхардсан, зорилго нь тодорхойгүй дэмжлэгийг үе шаттай зогсоох буюу шинэчлэх.
9. **Хэлэлцэгдээгүй үлдсэн асуудлыг тусдаа парламентын хяналтаар үргэлжлүүлэх.** 2026 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр ирц хүрээгүйн улмаас хэлэлцэгдээгүй

хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн татаас, "Шинэ хоршоо", "Хүнсний хангамж, аюулгүй байдал", ноос, ноолуур, "Цагаан алт", "Атар-4" болон бусад томоохон бодлого, хөтөлбөрийн санхүүжилт, хүртээмж, эргэн төлөлт, үр дүнг тусгайлан хамруулсан парламентын хяналт шалгалтын хэлбэрийг Байнгын хорооноос сонгон хэрэгжүүлэх. Энэ хүрээнд эхлээд шаардлагатай баримт, мэдээллийг бүрэн гаргуулж, дараа нь хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, тусгай шалгалт явуулах асуудлыг шийдвэрлэх.

ХАВСРАЛТ.ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН ҮНДСЭН МАТЕРИАЛ

- 2026.09.28-ны өдрийн Ерөнхий хяналтын сонсголын хөтөлбөр;
- ХХААХҮ-ийн сайдын "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын танилцуулга";
- ХХААХҮЯ-ны "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгосон дэмжлэг, түүний хэрэгжилт, үр дүн" танилцуулга;
- "ХХААХҮ-ийн салбарт олгосон төрийн дэмжлэгийн хэрэгжилт, үр дүн 2008-2025" шинжээчийн дүгнэлт;
- ХХААХҮЯ-ны "Төрөөс олгож байгаа урамшууллын төрөл, хүртээмж, үр дүн" танилцуулга;
- Үндэсний аудитын газрын "ХХААХҮ-ийн салбарт гадаадын зээл, тусламж, улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний аудитын үр дүн" танилцуулга;
- "ХХААХҮ-ийн салбарт олгосон төрийн урамшууллын хэрэгжилт, үр дүн 2008-2025" шинжээчийн дүгнэлт;
- 2026.09.28-ны өдрийн сонсголын дэлгэрэнгүй тэмдэглэл;
- 2026.09.28, 29-ний өдрүүдэд танилцуулахаар бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээлэл;
- Сонсголын оролцогчдын бүртгэлийн мэдээлэл.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА М.МАНДХАЙ